



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2000 оны 11 дугаар
сарын 08 -ны өдөр

Дугаар 390

Улаанбаатар хот

Тогтоол хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2000 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн "Нийгмийн дэг журмыг бэхжүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай 18 дугаар тоот тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих хотын комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах дүрмийг хоёрдугаар, зөвшөөрөл авсан газруудтай хийх гэрээний үлгэрчилсэн загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баглан, 2000 оны 11 дүгээр сарын 15-наас ажиллуулсугай.

Хоёр. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих хотын комисс /Т.Бадамжунай /-т үүрэг болгох нь.

1.Бэлтгэл ажлыг энэ оны 11 дүгээр сарын 20-ны дотор бүрэн хангаж, урьд нь зөвшөөрөлтэй ажиллаж байсан болон шинээр хүсэлт гаргасан газруудыг бүрэн аттестатчиллах арга хэмжээ авсугай.

2.Аттестатчиллын явцад 24 цагийн ажиллагаатай хүнсний дэлгүүрийн асуудлыг авч үзэн цэгцлэх арга хэмжээ авсугай.

3.Энэ онд багтаан аттестатчиллын дүн зөвшөөрөл олгосон тухай мэдээлэл бэлтгэж хотын удирдлагуудад танилцуулсугай.

4.Захирамжийн хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж ажиллалсугай.

Гурав. Согтууруулах ундаа худалдах, түүгээр зөвшөөрөл олгох, хяналт тавих комиссоос шийдвэр гарган архи, согтууруулах ундаа худалдах эрх нь цуцлагдсан цэг салбарын үйл ажиллагаанд хяналт тавьж, бүрэн зохиож ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга нар, хотын Цагдаагийн газар /Н.Ганболд /-т үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2000 оны 6 дугаар сарын 15-ны "Тогтоол хэрэгжүүлэх тухай" 187 тоот захирамжийн хүчингүй болгогч тооцогсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2000 оны
390 тоот захирамжийн 1-р хавсралт

**СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛЦАХ, ТҮҮГЭЭР
ҮЙЛЧЛӨХ ЗӨВШӨӨРӨН ОЛГОХ ХЯНАЛТ ТАВИХ
ХОТЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга	- Улаанбаатар хотын ерөнхий менежер
Орлогч дарга	- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга
Нэрийн бичгийн дарга	- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд	- Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын дэд дарга - Нийслэлийн Засаг даргын хуулийн зөвлөх - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга - Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын хэв журмын хэлтсийн дарга - Хотын Эрүүл ахуй хэлдвэр судлалын хяналтын албаны дарга - Хотын Татварын газрын хяналтын хэлтсийн дарга - Дүүргүүдийн Засаг даргын орлогчид - Дүүргүүдийн ЭАХСХА-ны дарга нар - УБТЗ-ын Тээврийн хяналтын албаны худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан улсын ахлах байцаагч

**СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР
ҮЙЛЧЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ХОТЫН
КОМИССЫН АЖИЛЛАХ ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Сogтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих хотын комисс \ цаашид комисс гэнэ.\ үйл ажиллагаандаа Монгол улсын холбогдох хууль тогтоомж, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол болон Засаг даргын захирамжаар батлагдсан журмыг мөрдөж ажиллана.
- 1.2 Комисс нийслэлийн нутаг дэвсгэр дээр согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхтэй холбогдсон аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зохицуулах, тэдгээрт зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэх, түүнчлэн хотын нийгмийн дэг журмыг хангах зөвлөлтэй хамтран Монгол улсын холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, архидан согтуурахтай тэмцэх, хор уршгийг олон нийтэд таниулан ойлгуулах, хяналт тавих ажлыг зохион байгуулна.

Хоёр. Комиссын дотоод ажил

- 2.1 Комисс нь согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжийн хүсэлтийг шууд хүлээж авах бөгөөд хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор энэ журмын дагуу шалгаж, стандарт, үзүүлэлт бүхий хүснэгтээр биелэлт гаргаж, шаардлага хангасан аж ахуйн нэгжийн материалыг бүрдүүлэн хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 2.2 Хүнсний бөөний төвд согтууруулах ундаа худалдах зөвшөөрөл олгох тухай асуудлыг нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан тохиолдолд хэлэлцэнэ.
- 2.3 Комисс нь сард 1-ээс доошгүй удаа, нийт гишүүдийн 60 хувиас дээш ирцтэй нөхцөлд хуралдана. Хурлаар зөвшөөрөл хүссэн газруудыг хэлэлцээд, нийт гишүүдийн 75-аас доошгүй хувийн санал авсан аж ахуйн нэгжүүдэд тогтоол гаргаж зөвшөөрөл олгоно. Тогтоолд комиссын дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 2.4 Комисс нь тогтоолын хуулбарыг хотын Цагдаагийн болон Татварын газар, дүүргүүдийн Засаг даргын тамгын газарт хүргүүлнэ.
- 2.5 Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгуулсан гэрээнд тусгасан зөрчил гаргасан тохиолдолд комисс шийдвэр гаргаж зөвшөөрлийг хүчингүй болгоно.

- 2.6 Комиссын зүгээс зөвшөөрөл олгосон газруудад тусгай удирдамжтайгаар үзлэг, шалгалт хийж ажиллана.
- 2.7 Комисс үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах тогтоол, хурлын тэмдэглэл, албан шаардлага, мэдэгдэл, шалгах хүснэгт, зөрчлийн акт, зөвшөөрөл зэрэг маягтыг хэвлүүлж хэрэглэнэ.
- 2.8 Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийн хураамжийг комиссын дэргэд нээсэн тусгай дансанд төвлөрүүлж, тэмдэгтийн хураамжийг цэгийн тоогоор улсын орлогод оруулан, үлдэх хэсгийг комиссоос хяналт тавих, шөнийн цагт унаа, хүн хүч дайчлан шалгалт хийх, бичиг цаас, техник хэрэгслийн зардал, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, архидан согтуурахтай тэмцэх, түүний хор уршгийг арилгахад зориулан, зарцуулна.
- 2.9 Комисс ажлаа нийслэлийн нийгмийн дэг журмыг хангах зөвлөлийн ажилтай нягт уялдуулан архидан согтуурахтай тэмцэх хүрээнд хяналт тавих тодорхой төлөвлөгөө, графиктай ажиллах бөгөөд зохион байгуулж хийсэн ажлаа улирал тутам нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн болон Засаг даргын зөвлөлийн хуралд мэдээлж байна.
- 2.10 Монгол улсын холбогдох хууль тогтоомж, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамжаар батлагдсан журам, зааврыг зөрчсөн үйл ажиллагаа явуулсан, буруу шийдвэр гаргасан тохиолдолд шаардлагатай гэж үзвэл нийслэлийн Засаг дарга гаргасан тогтоолыг хүчингүй болгож өөрчилнө.

Нийслэлийн Засаг даргын
2000 оны 390 тоот захирамжийн
3-р хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ГЭРЭЭНИЙ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

БАТЛАВ
Хотын СУХТҮЗОХТК-ийн

200 . оны . . сарын . . . өдөр

БАТЛАВ
Аж ахуйн нэгжийн захирал

200 . оны . . сарын . . . өдөр

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ГЭРЭЭ

Дугаар

Нэг талаас Сogтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих хотын \цаашид комисс гэх\ комисс, нөгөө талаас \цаашид аж ахуйн нэгж гэх\ хамтран дараахь нөхцлүүдийг хэлэлцэн тохиролцож, харилцан зөвшөөрснөөр энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний зүйл

- 1.1 Комисс согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй дор дурьдсан нөхцөл хугацаагаар үйл ажиллагааг нь эрхлүүлэхээр тохирлоо.
- 1.2 Гэрээний хугацаа нь хотын комиссын тогтоол гарснаас хойш 2 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

Хоёр. Комиссын хүлээх үүрэг

- 2.1 Аж ахуйн нэгжид хэрэгжүүлбэл зохих хууль, тогтоомж, мөрдөх журам, заавар дүрмийг сурталчлах, танин мэдүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулна.
- 2.2 Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллана.

Гурав. Аж ахуйн нэгжийн үүрэг

- 3.1 Үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд, журмыг чанд баримтлаж ажиллана.
- 3.2 Тогтоосон цагийн хуваарийг хатуу баримтлан ажиллана.
- 3.3 Зөвхөн чанар, стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүнийг худалдаална.

- 3.4 Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх явцад үйлчилгээний дэг журамд онцгой анхаарч, согтуу буюу насанд хүрээгүй хүнд үйлчлэх, хэт чанга хөгжим тавих зэргээр нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах аливаа зөрчлийг гаргахгүй байх асуудлыг бүрэн хариуцна.
- 3.5 Үйл ажиллагааны талаар бүх шатны төрийн захиргааны болон мэргэжлийн хяналтын байгууллага, эрх бүхий албан тушаалтан, улсын байцаагчаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, үйлчлүүлэгчдээс гарсан санал, гомдлыг барагдуулах талаар санаачлагатай ажиллана.
- 3.6 Хот, дүүргээс нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, архидан согтуурахтай тэмцэх болон үйлчилгээний дэг журмыг сайжруулах талаар зохион байгуулж байгаа ажилд идэвхитэй оролцоно.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

- 4.1 Дараахь зөрчил гарсан тохиолдолд гэрээг цуцааж, зөвшөөрлийг шууд хүчингүй болгоно. Үүнд:
- 4.1.1 Цагийн хуваарь зөрчсөн
- 4.1.2 Чанар, стандартын баталгаагүй архи, согтууруулах ундаа худалдсан
- 4.1.3 Дан согтууруулах ундаагаар үйлчилсэн
- 4.1.4 Шөнийн цагаар чанга хөгжим тавих, хэт согтуу хүн буюу 18 насанд хүрээгүй хүүхдэд үйлчлэх зэрэг нийтийн амгалан тайван байдал, дэг журмыг алдагдуулсан
- 4.1.5 Согтууруулах ундаагаар үйлчлэхтэй зэрэгцүүлж аливаа хууль бус үйл ажиллагаа \ диско баарын дэргэд хоногийн өрөө ажиллуулах зэрэг\ явуулсан
- 4.2 Гэрээний үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг буруутай тал хариуцна.

Тав. Маргаан шийдвэрлэх журам

- 5.1 Энэ гэрээтэй холбогдон үүссэн аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд эвийн журмаар хэлэлцэн шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
- 5.2 Маргааныг хэлэлцэн шийдвэрлэх боломжгүй бол хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

Зургаа. Бусад

- 6.1 Энэ гэрээнд оруулах нэмэлт өөрчлөлт нь гагцхүү бичгээр үйлдэгдэж, талуудын төлөөлөг нар гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 6.2 Энэ гэрээг 2 эх хувь үйлдэж, 200 . . . оны . . . сарын . . . өдөр Улаанбаатар хотод гарын үсэг зурав.

ХОТЫН КОМИССЫГ ТӨЛӨӨЛЖ:

АЖ АХУЙН НЭГЖИЙГ ТӨЛӨӨЛЖ:

.....

.....